210804	Тээврийн хэрэгслийн татвар	700,000.00	319,225.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,013,500.00	14,064,190.00
210807	Газрын төлбөр	20,000.00	20,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>91,350,000.00</b>	<b>87,678,133.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,350,000.00	87,678,133.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,324,500.00</b>	<b>31,510,312.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,324,500.00</b>	<b>31,510,312.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9,460,000.00	8,998,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,524,500.00	9,524,406.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,340,000.00	12,987,506.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>585,074,100.00</b>	<b>345,915,765.04</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>585,074,100.00</b>	<b>345,915,765.04</b>
220001	Барилга байгууламж	370,110,500.00	222,611,015.04
221001	Их засвар	70,000,000.00	

			19,249,700.00
222001	Тоног төхөөрөмж	40,000,000.00	39,900,000.00
223001	Бусад хөрөнгө	104,963,600.00	64,155,050.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>226,012,400.00</b>	<b>117,000,000.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	226,012,400.00	117,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,981,816,500.00	1,498,095,288.02
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	344,068,200.00	344,068,200.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	344,068,200.00	344,068,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,338,688,300.00</b>	<b>1,115,246,898.02</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,338,688,300.00	1,115,246,898.02
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>299,060,000.00</b>	<b>38,780,190.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	131,050,900.00	38,780,190.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	156,009,100.00	.
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		162,511,354.16
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		127,604,348.06
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	500	5.00
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	49.00	49.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	27.00	27.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>49.00</b>	<b>49.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31.00	31.00
650010	Гэрээт ажилтан	8.00	3.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>60,330,305.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>60,330,305.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	25,411,265.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	6,558,665.00
210303	Цэвэр, бохир ус		6,558,665.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>1,558,600.00</b>
210401	Бичиг хэрэг		245,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,263,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		50,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>10,114,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,490,000.00
210604	Урсгал засвар		5,624,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	<b>3,800,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,800,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>3,380,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		2,980,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		400,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>700,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		700,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>34,219,040.29</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1,004,225.29
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		33,214,815.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>59,326,080.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	59,326,080.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,369,815.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,313,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		<b>27,642,665.00</b>

131106	Төсвийн урамшуулал		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		(1,004,225.29)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,004,225.29
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын үйл ажиллагааны гол зорилгоо “Монгол улсын үндсэн хууль, бусад хууль аймаг сумын удирдлагын бодлогыг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан төр иргэний харилцааг ил тод нээлттэй болгож, иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлэн үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд манай хамт олны эрхэм зорилго оршино. Төрийн албаны нэгдмэл байдлыг хангаж төрийн бодлого шийдвэрийг иргэдэд шуурхай үзүүлж, төрийн бодлого шийдвэрийг цаг алдалгүй хэрэгжүүлэх” гэж чиг үүргээ тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

2021 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Санхүү, төрийн сангийн хэлтэс болон санхүү хяналт аудитын алба санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийдэг байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь нийтлэг мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн бүртгэл хөтөлдөг бөгөөд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай болох шаардлагатай байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,496.3 сая төгрөгөөр буюу 35 хувиар буурсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 350.7 сая, эцсийн үлдэгдэл 215.5 сая төгрөг болж, 135.2 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<i>Касст байгаа бэлэн мөнгө</i>	0.06	0.12	+0.06	0.02
<i>Банканд байгаа бэлэн мөнгө</i>	10.2	1.9	-8.3	0.9
<i>Төрийн сангийн харилцах</i>	339.5	213.5	-126.0	99
<i>Нэмэлт санхүүжилт</i>	1.,0		-1.0	-
<b>Дүн</b>	<b>350.7</b>	<b>215.5</b>	<b>-135.2</b>	<b>100</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 215.5 сая төгрөгийн 213.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 0.12 сая төгрөг касст байгаа бэлэн мөнгө, 1.9 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 252,4 сая, эцсийн үлдэгдэл 299,7 сая төгрөг болж, 47,3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<i>Ажиллагчидтай холбогдсон авлага</i>	0,9	0,9	
<i>Төлбөртэй үйлчилгээний авлага</i>	54,3	0	-54,8
<i>Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/</i>	0,4	5,5	5,2
<i>Байгууллагаас авах авлага</i>	47,9	46,1	-1,8
<i>Хувь хүмүүсээс авах авлага</i>	148,9	247,1	98,2
<b>Дүн</b>	<b>252,4</b>	<b>299,7</b>	<b>47,3</b>

*Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага байгаа бөгөөд Дарьганга тохижилт ОНӨААТҮГ-ын өмнөх жилүүдэд үүссэн авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүйгээс олон жилийн насжилттай авлага үүссэн байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 205,1 сая, эцсийн үлдэгдэл 215,4 сая төгрөг болж, 10.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<i>Тусгай зориулалттай материал</i>	11,1	0	-11,1
<i>Эм боох материал</i>	44,5	42,0	-2,5
<i>Бэлэн бүтээгдэхүүн</i>	0,12	0	-0,12
<i>Бичиг хэргийн материал</i>	7,2	1,9	-5,3
<i>Аж ахуйн материал</i>	85,9	33,3	-52,6
<i>Сэлбэг хэрэгсэл</i>	1,9	1,7	-0,2
<i>Түлш тослох материал</i>	0,8	0	-0,8
<i>Барилга засварын материал</i>	6,7	0	-6,7
<i>Хүнсний материал</i>	4,7	0	-4,7
<i>Бусад хангамжийн материал</i>	25,9	70,6	44,7
<i>Мал амьтад</i>	16,1	65,9	49,8
<b>Дүн</b>	<b>205,1</b>	<b>215,4</b>	<b>10,3</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны 205,1 сая төгрөгийн үлдэгдэлд аж ахуй, эм боох, түлш тослох, бусад хангамжийн материал болон мал амьтдын үлдэгдэл нь гол нөлөөлж байна. Мөн бараа материалын үлдэгдлийн 71.2 хувь буюу дийлэнхийг Дарьганга тохижилт ОНӨААТҮГ, ЗДТГазар эзэлж байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,778,6 сая, эцсийн үлдэгдэл 2,880,9 сая төгрөг болж, 1,897,7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<i>Барилга байгууламж</i>	2,971,7	1578,4	-1393,3
<i>Тээврийн хэрэгсэл</i>	364,1	348,1	-16,0
<i>Машин тоног төхөөрөмж</i>	516,4	162,0	-354,4
<i>Тавилга эд хогшил</i>	287,4	127,5	-159,9
<i>Зам гүүрний байгууламж</i>	43,3	43,3	0
<i>Түүх соёлын дурсгалт зүйл</i>	54,7	0	-54,7
<i>Номын фонд</i>	54,3	0	-54,3
<i>Бусад үндсэн хөрөнгө</i>	399,8	597,2	197,4
<i>Программ хангамж</i>	2,3	0,95	-1,35
<i>Бусад биет бус хөрөнгө</i>	84,6	23,4	-61,2
<b>Дүн</b>	<b>4,778,6</b>	<b>2,880,9</b>	<b>-1897,7</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 56,5 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 49,9 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 238,0 сая, төгрөг нийт 344,5 сая төгрөгөөр нэмэгдэж, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 2,242.4 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 964.7 сая, эцсийн үлдэгдэл 980.9 сая төгрөг болж, 16.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Ажилчидтай холбогдсон өглөг</i>	47,9	55,2	7,3	5,6
<i>Байгууллага төлөх өглөг</i>	94,5	118,8	24,3	12,1
<i>Хувь хүмүүст төлөх өглөг</i>	26,5	24,8	-1,7	2,5
<i>Татварын өглөг /ТӨҮГ/</i>	22,3	31,2	8,9	3,2
<i>НДШ-ийн өглөг /ТӨҮГ/</i>	10,4	11,4	1	1,2
<i>Дансны өглөг /ТӨҮГ/</i>				
<i>Бусад урьдчилж орсон орлого</i>	763,0	739,5	-23,5	75,3
<b>Нийт дүн</b>	<b>964,7</b>	<b>980,9</b>	<b>16,2</b>	<b>100</b>

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ажилчидтай холбоотой 55.2 сая, байгууллагад төлөх 118,8 сая, хувь хүнд төлөх 24.8 сая, татварын 31.2 сая, НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ 11.4 сая, урьдчилж орсон орлого төгрөгийн 739.5 сая нийт 980,9 сая төгрөгийн өр төлбөртэй байна. Өр төлбөрийн дийлэнх хувийг Дарьганга тохижилт ОНӨААТҮГ-ын үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэж, жил бүр капиталжуулж байгаа нь нөлөөлсөн байна

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,280,5 сая, эцсийн үлдэгдэл 1,767.9 сая төгрөг болж, 1,512.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № .6 ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт -/	Дүнд эзлэх хувь
<i>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</i>	3764,5	682,8	-3081,7	
<i>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</i>	2,1	11,8	9,7	
<i>Хуримтлагдсан үр дүн</i>	-822,5	1026,1	203,6	
<i>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</i>	336,3	47,0	-289,3	
<b>Дүн</b>	<b>3,280,4</b>	<b>1767,9</b>	<b>-1,512.6</b>	

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 203.6 сая төгрөг болж өссөн нь тайлант үеийн 1,314.6 сая төгрөгийн үр дүнгийн бууралт, 2021 оны хуримтлагдсан үр дүнгийн 1.518.4 сая төгрөгийн өсөлтийн үр нөлөө болно.

### 3.5 Орлогын данс

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн А/03 дугаар тогтоолд зааснаар сумын төсвийн татварын орлого 476.6 сая төгрөг, татварын бус орлого 25.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 386.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэл 77 хувьтай хэрэгжсэн байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>476.6</b>	<b>366.5</b>	<b>(110.1)</b>	<b>76.9%</b>
Орлогын албан татвар	218.0	230.6	(12.6)	105.8%
Хувь хүний орлогын албан татвар	<b>218.0</b>	<b>230.6</b>	<b>(12.6)</b>	<b>105.8%</b>
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	140.0	164.9	24.9	118.0
Үйл ажиллагааны орлого	25.0	22.2	(2.8)	89%
Хөрөнгийн орлого	50.0	40.8	(9.1)	81.7%
Хөрөнгө борлуулсны орлого	<b>3.0</b>	<b>2.6</b>	<b>(0.4)</b>	<b>86.7%</b>
Хөрөнгийн албан татвар	<b>184.6</b>	<b>57.8</b>	<b>(126.8)</b>	<b>31.3%</b>
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2.5	5.0	2.5	201%
Бууны албан татвар	0.9	1.0	(0.1)	117.9%
Малын тоо толгойн албан татвар	181.2	51.8	(129.4)	28.5%
Бусад татвар, төлбөр, хураамж	<b>74.0</b>	<b>78.1</b>	<b>4.1</b>	<b>105.5%</b>
Бусад нийтлэг төлбөр, хураамж	24.5	8.1	(16.4)	33.2%
Улсын тэмдэгтийн хураамж	2.0	1.9	(0.1)	96.3%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2.5		(2.5)	0.0%
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	20.0	6.2	(13.8)	31%
Газрын төлбөр	<b>5.7</b>	<b>3.3</b>	<b>(2.4)</b>	<b>58.8%</b>
Газрын төлбөр	5.7	3.3	(2.4)	58.8%
Байгалийн нөөц ашигласны төлбөр	<b>43.8</b>	<b>66.6</b>	<b>22.8</b>	<b>152%</b>
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	27.3	61.3	34.0	152%
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.5	1.0	(0.5)	64%
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	15.0	4.3	(10.7)	28.6%
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25.0</b>	<b>19.8</b>	<b>(492.3)</b>	<b>11.8%</b>
Торгуулийн орлого	25.0	19.8	(5.2)	79.4%
<b>ТӨСВИЙН ОРЛОГО</b>	<b>501.6</b>	<b>386.3</b>	<b>(115.3)</b>	<b>77%</b>

Засгийн газрын тогтоолоор цалин хөлсний хэмжээнд өөрчлөлт орсны улмаас цалингийн ашиг 164.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 24.9 сая төгрөгөөр давсан байна.

Үйл ажиллагааны орлого: 2022 оноос үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн хялбаршуулсан горимоор тайланг авч малчдын арьс шир, ноос, ноолуурын орлогоос 22.2 сая төгрөгийн татварын орлого орсон.

Иргэдийн орлого буурсантай шууд уялдан арилжааны банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжийн хэмжээ буурч, 9.1 сая төгрөгөөр гүйцэтгэл тасарсан.

Малын тоо толгойн албан татварыг 181.2 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 51.7 сая төгрөгийн орлого төвлөрч, 129.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Үл хөдлөх хөрөнгийн татвар төлөвлөснөөс 2.5 сая төгрөгөөр давсан байна. Бууны албан татвараас 1.0 сая төгрөг төвлөрсөн. Газрын төлбөрт 3.3 сая төгрөг, ургамал ашигласны төлбөрт 4.3 сая төгрөг төвлөрч, 10.7 сая төгрөгөөр тасарсан.

Замын хөдөлгөөний шинэ хууль батлагдсантай холбоотойгоор торгуулийн орлого 19,8 сая төгрөг төсөвт орж төлөвлөгөө 5.2 сая төгрөгөөр тасарсан байна.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 1,635,0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 812.3 сая төгрөгийг урсгал зардалд, 585.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 227,3 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас олгох зээлд зарцуулахаар батлагджээ. Үүнд:

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,696.4 сая төгрөг, нийт зардлыг 1.696.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн санал болох 1,696.4 сая төгрөгийн зардлыг 61.3 сая төгрөгөөр бууруулж, 1,635.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийн баталсан байна.

Энэ нь сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагуудын төрийн үйлчилгээний ажиллагсдын цалинг 5 сараас эхлэн төсвөөс санхүүжүүлэхгүй болсонтой холбоотойгоор санхүүжилтийн хэмжээ буурснаас шалтгаалсан байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,526,5 сая төгрөг буюу 90,7 хувьтай байгаа нь харилцах дансны үлдэгдэл төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

*Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	76.4	70.6	5.8	92%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	11.3	10.7	0.6	95%
4	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	15.0	15.0	0.0	100%
5	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	15.0	11.1	3.9	74%
6	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал	0.3		0.3	0%
Дүн		<b>118.0</b>	<b>107.4</b>	<b>10.3</b>	
70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	358.5	330.4	28.1	92%
2	80103-Гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	7.7	6.5	1.2	84%
2	80106- Баг хорооны үндсэн үйл ажиллагаа	59.8	58.8	1.0	98%

3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	9.5	9.0	0.5	95%
4	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	11.3	7.5	3.8	66%
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	60.0	59.9	0.1	100%
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	119.3	108.4	10.9	91%
7	81549- Ахмадын сан	1.2	0.9	0.3	75%
8	81701- Байгаль хамгаалах ,нөхөн сэргээх зардал	9.4	8.8	0.6	94%
9	82706-гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал	3.5	3.4	0.1	97%
10	83201-Ангилагдаагүй бусад зардал	5.0	3.0	2	0.6
Дүн		<b>636.7</b>	<b>596.6</b>	<b>48.6</b>	
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал		43.1		
	83201-Ангилагдаагүй бусад зардал		4.5		
Дүн		<b>0.0</b>	<b>47.6</b>	<b>0.0</b>	
71802 ерөнхий боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал		113.2		
2	80112-нийтлэг үйлчилгээ	41.6	41.6	0.0	100%
3	83201-мэдээлэл технологи				
Дүн		<b>41.6</b>	<b>154.8</b>	<b>0.0</b>	
71801 сургуулийн өмнөх боловсрол					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал		50.5		
2	80112-нийтлэг үйлчилгээ	23.6	23.6	0.0	100.0%
3	83201-мэдээлэл технологи		11.9		
Дүн		<b>23.6</b>	<b>86.0</b>	-	364.4%
71702 соёл урлаг					
1	80111-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал		58.4		
2	80112-нийтлэг үйлчилгээ	2.8	2.8	0.0	100.0%
	83201-мэдээлэл технологи		9.9		
Дүн		<b>2.8</b>	<b>71.1</b>	<b>0.0</b>	2539.3%
Орон нутгийн хөгжлийн сан хөтөлбөр бичих					
1	83401-итгэлцүүрээр	344.1	214.7	129.4	62.4%
2	83405-малын тоо толгойн албан татвар	181.2	91.3	89.9	50.4%
3	83406-ОНХС-бусад	59.7	39.9	19.8	66.8%
Дүн		<b>585.0</b>	<b>345.9</b>	<b>239.1</b>	59.13%
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих					
1	82611-жижиг дунд үйлдвэрлэл дэмжих	1.3	0.1	1.2	7.7%
2	83111-сум хөгжүүлэх	226.0	117.0	109.0	51.8%
Дүн		<b>227.3</b>	<b>117.1</b>	<b>110.2</b>	51.5%
Нийт дүн		<b>1,635.0</b>	<b>1,526.5</b>	<b>108.5</b>	<b>93.4%</b>

Орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөрт тусгасан зарим арга хэмжээг дутуу санхүүжигдсэн байна.

Тусгай зориулалтын байгууллага болон ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн байгууллагын тогтмол зардал болон мэдээлэл технологийн зардал нь аймгийн төсвөөс санхүүжжээ.

### **3.5.2 Нэмэлт төсөв:**

ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 30.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 27.6 сая нийт 59,3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 6.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 1.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 10.1 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3,8 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 3.4 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 0.7 сая төгрөг нийт 60.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл -1.0 сая төгрөг болжээ .

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Миндүг аудит ХХК–ны аудитор О.Цагаан гүйцэтгэж, туслах аудитор Ш.Ундрах, чанарын хяналтыг аудитор Б.Бүзмаа , хяналтыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Даваа , дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг Дарга нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Миндүг аудит ХХК–д 2023 оны 02 дүгээр сарын 24 -ны өдрийн 2/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар буюу 59.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 44.9 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дугаар зүйл 14.1, 14.4 дэх /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглох/ заалтыг зөрчиж Засаг даргын тамгын газар 19.2 сая төгрөгийн ширээ , сандал , зөөврийн болон суурин компьютерыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

#### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Шилэн дансны цахим системд тайлант хугацаанд оруулбал зохих 124 мэдээллээс 17 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

##### **4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг Дарга нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудалгүй байна.

#### **4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.7.1 Завсрын аудитын талаар**

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 2022 онд завсрын аудит хийгээгүй.

##### **4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 83.5 хувьтай байна .

*Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт / сая төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	32.2	1	21.6	67.0
Залруулга	1	102.0	1	102.0	100
Нийт дүн	2	134.2	2	123.6	83.5

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сум хөгжүүлэх сангаас олгогдсон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах, шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулах, байгууллага бүрийн өөрийн онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулан, мөрдөж ажилласан байдлыг аудитад хамруулах

#### 5. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### 5.1 Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой:

###### 5.1.1 Илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татвар 14.9 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 /Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна/, 5.2 /Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно./, 6 дугаар зүйлийн 6.2 /Албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал малын төрөл тус бүрээр тогтооно/, 7 дугаар зүйлийн 7.1 /Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө/, Төсвийн тухай хуулийн 41 дугаар зүйлийн 41.2.1 /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, тус тус зөрчсөн байна.

###### 5.1.2 Эрсдэл:

Төсвийн орлого дутуу төвлөрөх, энэ нөлөөллөөр хөтөлбөр арга хэмжээ тасрах

###### 5.1.3 Өгсөн зөвлөмж:

Малын тоо толгойн албан татварыг төвлөрүүлэх чиглэлээр Багийн засаг дарга, татварын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ болгон тусгаж, биелэлтийг хангуулах, мөн уг албан татвараар төвлөрсөн хөрөнгийг буцаан малчдад үйлчилгээ үзүүлэх тохиолдолд татвар төлсөн байдлыг шалгуур үзүүлэлт болгон авч үзэхийг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/сая төгрөгөөр/**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	3	19.2			1	0	2	19.2				
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	13.0	1	1.0			2	12.0				
Орон нутгийн хөгжлийн сан	4	183.7			4	183.7						
Сум хөгжүүлэх сан	2	53.2					2	53.2				
Дарьганга тохижилт ОНӨҮГ	1	1.3	1	1.3								
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>270.4</b>	<b>2</b>	<b>2.3</b>	<b>5</b>	<b>183.7</b>	<b>6</b>	<b>84.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/сая төгрөгөөр/**

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Засаг даргын тамгын газар	1	0		0	1	0		
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0			1	0		
Орон нутгийн хөгжлийн сан	3	0	1	0	1	0	1	0
Сум хөгжүүлэх сан	1	0	1	0	1	0		
Дарьганга тохижилт ОНӨҮГ								
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>